

**ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН
ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ**

/Шинэчилсэн найруулга/

2013 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр

Хуулийн нэр	Хуулийн зорилго	Худалдаатай холбоотой заалтууд
<p>ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ</p> <p>/Шинэчилсэн найруулга/ 2013 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр</p>	<p>1.1.Энэ хуулийн зорилт нь үйлдвэрлэлийн зориулалттай тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих, тэдгээрийн хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй ажиллагааг хангах, хууль бус хэрэглээг хориглохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p>	<p>6 дугаар зүйл.Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх</p> <p>6.1.2.тэсэлгээний ажил гүйцэтгэх, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, худалдах, тэсэлгээний ажил, үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийг Мэргэжлийн зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн олгох;</p> <p>13 дугаар зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл худалдахад тавих шаардлага</p> <p>13.1.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох тусгай зөвшөөрөлтэй этгээд тэдгээрийг зөвхөн энэ хуулийн 15.1-д заасан хуулийн этгээдэд худалдана.</p> <p>13.2.Гамшгаас хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хураагдсан тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг мэргэжлийн байгууллагын хяналтын дор тэсэлгээний ажил явуулах эрх бүхий байгууллагад худалдах буюу шинэчлэн сэлгэн сольж байршуулж болох ба энэ тухайгаа энэ хуулийн 22 дугаар зүйлд заасан нэгдсэн мэдээллийн санд тухай бүр мэдэгдэнэ.</p> <p>22.3.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрлэл, импорт, экспорт, худалдаа, ашиглалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээд нь үйлдвэрлэсэн, импортолсон, экспортолсон, худалдсан, ашигласан тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн орлого, зарлагын мэдээг тухай бүр энэ хуулийн 22.1-д заасан мэдээллийн нэгдсэн санд хүргүүлнэ.</p>